

АМЕРИК - ХЯТАДЫН ГАДААД ХУДАЛДААНЫ АЛДАГДАЛ*Н.Хосбаяр**

Олон улсын худалдааны практикт гадаад худалдааны алдагдлыг тухайн улс орон бүрт эерэг, сөрөг үр дагавартай харьцангуй ойлголт гэж үздэг. Гадаад худалдааны алдагдал, тодруулж хэлбэл сөрөг цэвэр экспорт нь нийлмэл эрэлтийг бууруулж, үндэсний үйлдвэрлэлийн бодит хэмжээ, ажил эрхлэлтийг бууруулдаг. Түүнээс гадна импортын өсөлт орон нутгийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвартай барааны үнийг бууруулдаг. Үндсэндээ экспортын зах зээлээс ихээхэн хамааралтай эсвэл импорттой амжилттай өрсөлдөж чаддаг салбарууд худалдааны алдагдлыг хязгаарлах нөлөөг амсаж байдаг аж. Олон улсын худалдаанд алдагдал хүлээж байгаа нь тухайн улс орны төлбөрийн чадвар хийгээд эдийн засаг нь сульдах хандлагатай байгаагийн шинж тэмдэг гэж үздэг. Тэгэхлээр гадаад худалдааны алдагдал буюу урсгал тооцооны балансын алдагдал бий болох үед хэрэглэгчдэд импортын барааны үнэ хямдарч ашигтай тусдаг ч тал бий. Эцсийн дүндээ гадаад худалдаа алдагдалтай байна гэдэг нь америкчуудын тухайн үедээ дэлхийн улс орнуудаас импортоор авч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ бусад оронд экспортлож байгаа хэмжээнээс их байна гэсэн үг.

Энэхүү жижиг өгүүлэлд Америкийн гадаад худалдааны хоёр дахь том түнш Хятадтай хийж буй худалдааны алдагдал, түүнийг бууруулах талаар АНУ-ын эрх баригчдын зүгээс авч буй арга хэмжээ, цаашдын чиг хандлагын талаар хөндөж үзэх оролдлого хийлээ. Өнгөрсөн зууны 90-ээд оноос АНУ-ын Хятадтай хийсэн худалдааны алдагдал өсч Америк, Японы хоорондын худалдааны алдагдлын зөрөөнөөс ч хол давсан юм. Америк Хятадыг маш том зах зээл гэж үзэж түүнд нэвтрэн орох оролдлого хийсээр ирсэн билээ. Түүний эхлэл нь 1972 онд АНУ-ын ерөнхийлөгч асан Ричард Никсон БНХАУ-д төрийн айлчлал хийснээр тавигдсан. Энэ үеэр Америкийн зүгээс Хятадтай хийх худалдаа, эдийн засгийн харилцаанд тогтоосон зарим хязгаарлалтыг цуцалсан явдал нь хоёр орны худалдааны харилцаа өрнөн хөгжихэд чухал хүчин зүйл болсон.

Гэсэн хэдий ч хятадтай хийж буй худалдааны алдагдал жил ирэх бүр өсч, хуурамч бараа бүтээгдэхүүн Америкт экспортлох явдал газар авч хоёр орны харилцаанд ч таагүй байдал үүсгэх болсон.

2002 онд Хятад улс АНУ-ын дэмжлэгтэйгээр ДХБ-д элссэн явдал хоёр орны худалдааг нээлттэй болгох чиглэлд олон жил үргэлжилсэн яриа хэлэлцээрийн бодит үр дүн болсон юм. ДХБ-ын гишүүн болсон


* Н.Хосбаяр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Хятад улс зарим зах зээлээ АНУ болон бусад улс орнуудад нээх, мөн зарим худалдааны гэрээ хэлэлцээрүүдээ шинэчилсэн юм.

Тухайлбал, АНУ-ын компаниуд Хятадад машины борлуулалт хийхэд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн. Түүнчлэн Америкийн компаниуд Хятадын цахилгаан холбооны компаниудын хувьцааны 50 хүртэл хувийг эзэмших, худалдааны даатгалын бодлогод хамрагдахыг зөвшөөрсөн гэх мэт.

Хятад улс хөдөө аж ахуйн барааныхаа тарифыг багасгах, экспортыг улсаас санхүүжүүлж байсныг зогсоох, компьютерийн программ хангамж болон уран сайхны кино, дуу, клип, бичлэг зэрэг оюуны өмчийг хамгаалах тал дээр эрс шийдэмгий алхам хийнэ гэдгээ БНХАУ-ын дарга Ху Жинтао 2006 оны 4 дүгээр сард АНУ-д хийсэн айлчлалын үеэр мэдэгдэв.¹ Дээрхи гэрээ хэлэлцээрүүдийн үр дүнд хоёр орны худалдааны эргэлт эрс өсч, 2007 оны байдлаар Хятад нь Америкийн гадаад худалдааны хоёрдох том түнш, Америкийн экспортын гуравдагч том зах зээл (Хонгконг ороод) болов.² Гэсэн хэдий ч Америкийн Хятадтай хийж буй гадаад худалдааны алдагдал буурсангүй улам бүр өсөх чиг хандлагатай байна. Америкийн гадаад худалдааны нийт алдагдал, түүний дотор Хятадтай хийж ирсэн худалдааны алдагдлын байдлыг дараах графикаас үзнэ үү.

АНУ-ын гадаад худалдааны алдагдал, түүний бүтэц



The Increase in the US Trade Deficit Has Largely Come from Outside China and East Asia


Sources: US Dept. of Commerce, US Dept. of the Treasury, US ITC

Статистикийн дээрхи баримтаас үзэхэд АНУ-ын гадаад худалдааны алдагдалд Зүүн Азийн орнуудын эзлэх хувь (Хятад ороод) 1997 онд 70% байсан бол 2006 он 45% болж буурсан хэдий ч Хятадтай хийж буй худалдааны алдагдал өмнөх онуудаас бага зэрэг өссөн байна. АНУ-ын хувьд 1991 онд ДНБ-ний 1,7 хувийг эзэлдэг байсан гадаад худалдааны алдагдал тасралтгүйгээр өсч 2006 онд 6,7 хувийг эзлэх болов. Ажилгүйдлийн түвшин 1991-1998 онд дунджаар 6 хувь байсан

бол 1999-2006 онтой харьцуулж харахад 5 хувь болж буурсан. Гэвч бүтэн цагийн ажилчдад олгодог нөхөн төлбөрийн хэмжээ 1991 онд 46,614.0 ам.доллар байснаа 1998 онд 50,523.0 ам.доллар, 2005 онд 55,703.0 ам.доллар болж өсчээ.³

Энэ нь юуг харуулж байна вэ гэвэл гадаад худалдааны алдагдлыг улс нуруундаа үүрч байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл гадаад худалдааны алдагдлыг улсын нөөц зээлийн хөрөнгөөр хааж буйг харуулж байгаа явдал юм. Статистикийн тоо баримтаас 1985-2007 оны хооронд Америкийн экспорт Хятадад, Хятадын экспорт Америкт ямар байдалтай явж ирснийг дараах хүснэгтээс үзнэ үү.

**Америк, Хятадын гадаад худалдааны эргэлт
(тэрбум ам.доллар)**



Эх сурвалж: U.S. Census Bureau, Foreign Trade Division, Data Dissemination Branch, Washington, D.C. 20233

Хүснэгтээс үзэхэд сүүлийн хорь гаруй жилийн туршид АНУ-ын Хятадтай хийсэн худалдааны алдагдал дунджаар 18,7 хувиар өсч ирсэн байна. Энэ хугацаанд Хятадын импорт болон АНУ-аас Хятадад экспортлох хэмжээ ч мөн өсчээ. 2005 онд Хятадын зах зээл нь АНУ-ын 6 дахь экспортын том зах зээл байсан бол өдгөө 2007 он гэхэд 4 дэх том зах зээл болсон байна. 2006 оны байдлаар АНУ, Хятадад 55,2 тэрбум ам.долларын экспорт хийсэн. Харин АНУ нь Хятадын хувьд худалдааны хамгийн том түнш (2007 онд 386,7 тэрбум ам.долларын худалдаа хийж 1-рт, Япон 263 тэрбум ам.долларын худалдаа хийж 2-рт), экспортын тэргүүлэгч (2007 онд 321,5 тэрбум ам.долларын экспортыг АНУ-д хийж 1-рт, Хонгконгт 184.4 тэрбум ам.долларын экспорт хийж 2-рт), том зах зээл нь болж байна.⁴ Хятадтай хийж байгаа Америкийн болоод бусад улс орны худалдаа эрс өсөн

нэмэгдэж байгаа нь Хятад улс худалдааны хориг саадуудаа тасралтгүй бууруулж байгаатай холбоотой.

Хятадын зах зээлд гаргаж буй АНУ-ын экспорт өсч байгааг дээрхи графикаас харж болно. Энэ үзүүлэлт хоёр улсын хооронд худалдаа хийх сонирхол, харилцан хөрөнгө оруулах сонирхол асар их байгааг харуулна.⁵ 2006 оны сүүлч гэхэд 300,000 гаруй мянган гадаадын үйлдвэр ажиллаж байгаагийн 20,000 гаруй мянган аж ахуй нэгж нь АНУ-ын хамтарсан хөрөнгө оруулалттай хувьцаат компани, гэрээт хамтарсан хөрөнгө оруулалттай, болон 100 хувь хөрөнгө оруулалттай компани үйлдвэрийн газрууд байна. 2006 онд л гэхэд АНУ-аас 4,655.0 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт Хятадад орсон байна.

АНУ-ын үндэстэн дамнасан компаниуд Хятадад шилжиж, хөрөнгө оруулалтын 10 орчим хувийн өсөлт, Хятадын протекционист худалдааны бодлого зэрэг нь худалдааг алдагдалтай болгож буй чухал хүчин зүйл төдийгүй АНУ Хятадаас импортлож буй импортын хэмжээг 7,3% өсгөж, АНУ-аас Хятадад экспортлох бараа бүтээгдэхүүний хэмжээг 2,1%-иар бууруулж байгаа болохыг АНУ-ын эдийн засгийн бодлогын институтын судлаач Жэймэс Бюркын судалгаа нотолсон байна.⁶

Америкийн Хятадад гаргадаг экспортын бүтэц, Хятадаас АНУ-д экспортлож буй барааны бүтцийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 1: АНУ-аас Хятадад экспортлож буй гол нэрийн бүтээгдэхүүн

(тэрбум ам.доллар)

*2006 оноос өөрчлөгдсөн байдал

Эх сурвалж: US International Trade Commission, US Department of Commerce, and US Census Bureau

| HS# | Commodity Description | Volume | % Change* |
|--------|---|--------|-----------|
| 85 | Электрон машин механизм, тоног төхөөрөмж | 10.7 | 4.8 |
| 84 | Эрчим хүчний тоног төхөөрөмж | 8.9 | 15.0 |
| 95 | Агаарын болоод сансрын хөлөг | 7.2 | 18.2 |
| 12 | Ургамын тосны үр & оливын жимс | 4.2 | 61.7 |
| 39 | Хуванцар пластик & түүнтэй холбоотой эд зүйлс | 3.6 | 32.6 |
| 90 | Оптик & эмнэлгийн тоног төхөөрөмж | 3.3 | 12.7 |
| 72, 73 | Төмөр & ган | 2.8 | 26.6 |
| 74 | Зэс & түүгээр хийсэн зүйл | 2.2 | 21.9 |
| 29 | Химийн органик бодис | 2.1 | 48.1 |
| 47 | Цаасны үйлдвэрийн түүхий эд, модны зөөлөн эд | 2.05 | 39.3 |

**Хүснэгт 2: Хятадаас АНУ-д экспортлож буй гол нэрийн
бүтээгдэхүүн
(2006 оны байдлаар тэрбум ам.доллар)**

*2005 оноос өөрчлөгдсөн байдал

Эх сурвалж: US International Trade Commission, US Department of Commerce, and US Census Bureau

| HS# | Commodity Description | Volume тоног | % Change* |
|--------|---|-----------------|-----------|
| 85 | Электрон машин механизм, төхөөрөмж | 76.7 | 18.2 |
| 84 | Эрчим хүчний тоног төхөөрөмж | 64.0 | 2.9 |
| 95 | Тоглоом | 26.1 | 25.1 |
| 61, 62 | Бэлэн хувцас | 24.0 | 20.7 |
| 94 | Тавилга | 20.4 | 5.2 |
| 64 | Гутал, түүнтэй ижилсэх зүйлс | 14.1 | 1.8 |
| 72, 73 | Төмөр, ган | 11.9 | 12.6 |
| 39 | Хуванцар зүйлс | 8.3 | 10.6 |
| 42 | Боловсруулсан арьс шир, дурсгалын зүйлс | 7.2 | 5.8 |

АНУ-ын Хятадаас импортлож буй бараа бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь ангилж үзвэл телефон болон гар утас, утасгүй болон утсан сүлжээний дамжуулах болон хүлээн авах эд анги, тоног төхөөрөмж, зурагт болон компютерийн дэлгэц, процессор, түүний эд анги дагалдах хэрэгсэл, бүх төрлийн камер, зураг дуу бичлэг хийх болон түүнийг дамжуулах, ашиглахтай холбоотой хэрэгсэл эд анги хагас дамжуулагчууд, кабель утас диск, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл бусад өргөн хэрэглээний цахилгаан бараа Хятадаас импортлож буй нийт импортын 24,3 хувийг эзлэж байгаа нь импортын бүтцийг өөрчлөж оюуны багтаамж шингээсэн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл Хятадад эрчимтэй хөгжсөнийг болон энэ төрлийн үйлдвэрлэгчид Хятадад хөрөнгө оруулалт хийж, салбар үйлдвэрлэлээ эрчимтэй оруулж байгааг харуулж байна.⁷

Цаашдаа хоёр улсын худалдааны эргэлт улам бүр өсөх бөгөөд Хятадтай хийж буй худалдааны ужиг алдагдал ч цаашдаа өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь Америкийн талаас дотоодын үйлдвэрлэгчдээ хамгаалах, ажилгүйдлийн түвшинг өсгөхгүй байх, гадаад худалдааныхаа балансыг тэнцвэржүүлэх үүднээс протекционист бодлого явуулах нөхцлийг бүрдүүлж байна. Хэдийгээр Хятадын Америкт гаргаж буй экспортын эрчимтэй өсөлт нь Америкийн хэрэглэгчдэд хямд бүтээгдэхүүн болон очиж байгаа хэдий ч дотоодын үйлдвэрлэлийн өсөлт хөгжлийг сааруулж, өрсөлдөх чадварыг бууруулж, ажилгүйдлийг нэмэгдүүлж ч болзошгүй. Тийм учраас АНУ тодорхой хугацаанд үндэсний үйлдвэрлэгчдээ хамгаалах бодлого арга хэмжээ авах нь гарцаагүй. Ийм хамгаалах бодлогыг тодорхой хүрээ

хязгаарын хүрээнд хэрэгжүүлэхийг ДХБ-аас зөвшөөрсөн заалт ч бий. Харин Хятадын хувьд АНУ-аас импортлож буй бараа бүтээгдэхүүн дотоодын үйлдвэрлэгчдийг хохироосон, хохироож болзошгүй гэсэн маргаан санал гомдол одоохондоо гараагүй байна.

Энэ нь Америкийн бүтээгдэхүүний чанар, үнэ, Хятадын хүн амын худалдан авах чадвар, зах зээлийн багтаамж, шингээх чадвар зэрэг олон хүчин зүйлстэй холбоотой юм.

Америкийн Хятадтай хийж буй гадаад худалдааны энэ асар их алдагдлын уг сурвалж нь юу болохыг судлаачид янз бүрээр тайлбарладаг. Үүнд хоёр үндсэн хүчин зүйлс нөлөөлж байна гэдэгт судлаачдын ихэнх нь санал нэгддэг. Энэ нь юуны өмнө юаний ханшаа сүүлийн 10 гаран жил тогтмол барьж ирсэнд оршино. Нөгөө талаар дотоодынх нь асар том зах зээл, аж ахуй эрхлэх ур чадвартай хямд, бөгөөд дадлага туршлагатай ажиллах хүчний арвин их нөөц нь гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татаж, үйлдвэрлэлийн өртөг зардал бага, гарах бүтээгдэхүүний өртөг хямд байгаатай холбон тайлбарлаж байна.⁸

Хятад хүчээр юаний ханшаа зах зээлийн өнөөгийн бодит ханшнаас даруй 40 орчим хувь доогуур барьж байгаа нь Хятадын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ АНУ-ын зах зээл дээр хямд, эсрэгээр АНУ-ын бараа бүтээгдэхүүн Хятадын зах зээл дээр үнэтэй байдлаар хэрэглэгчдэд хүрч байгаа юм. Энэ байдал Америкаас Хятад руу урсах валютын урсгалыг улам ихэсгэдэг.

2008 оны 1 сарын байдлаар Хятадын гадаад валютын нөөц нь 1589.9 тэрбум ам.долларт хүрч, дэлхийн нийт валютын нөөцийн 22 хувийг эзэмшиж буй цорын ганц орон болов.⁹ Хятадын гадаад валютын нөөц ийм их хэмжээгээр өсөхөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын асар их өсөлт ч нөлөө үзүүлдэг гол хүчин зүйл болдог. Хятад улсыг юаний ханшаа зах зээлийн зарчмаар чангаруулах шаардлагыг их долоогийн хуралдаанаар болон Хятадад болон Америкт эдгээр улсууд харилцан дээд хэмжээний айлчлал хийх үеэр, АНУ, ЕХ-ны зүгээс олонтаа шаардлага тавьсаар байгаа боловч энэ тал дээр ямар нэгэн дорвитой ахиц, өөрчлөлт өнөө хэр гарсангүй.

АНУ-ын сангийн сайд асан Жон Сноу Хятад улсын юаний ханшийг чангаруулах, валютын ханшны тал дээр хамтарч ажиллах асуудлаар Хятадад хоёр ч удаа айлчилж, яриа хэлэлцээр хийж байсан боловч Хятадын зүгээс асуудлыг шийдвэрлэх цаг нь болоогүй хэмээх тайлбар өгсөөр өдий хүрлээ. Энэ нь том хүчирхэг гүрнүүдийн үндэсний эдийн засгаа хамгаалах бодлого үйл ажиллагааны цар далайцыг илэрхийлж буй нэгэн үзүүлэлт юм.

ОУВС, Дэлхийн Банк жил бүрийн уулзалтаараа Хятад улс юаний ханшаа зах зээлийн жамаар чөлөөлөхгүй бол түүний экспортонд тариф ноогдуулах асуудлыг ДХБ-аар дамжуулан тавих тухай мэдэгдэж боловч ямарч үр дүнд хүрээгүй. Америкчууд Хятадын бэлэн хувцас, нэхмэл сүлжмэл бараанд тавьсан квотын хугацаа энэ онд дуусаж байгаа нь гадаад худалдааны алдагдлыг нэмэгдүүлэх бас нэгэн хүчин зүйл болж болзошгүй.

2006 онд Хятадын ерөнхийлөгч Ху Жинтао АНУ-д хийсэн айлчлалаа төр засгийн тэргүүнтэй нь бус Microsoft компаниас эхлэж Билл Гэйтстэй уулзаж Хятадын засгийн газар софт системийн хууль бус хулгайн эсрэг хүчтэй тэмцэхээ амлаж, цаашдаа Хятадад борлуулах бүх компьютерт хуулийн дагуу софт систем худалдан авч байхаар болсон. Энэхүү айлчлалаас хэдхэн хоногийн өмнө БНХАУ-ын ерөнхий сайдын орлогч У И хатагтай АНУ-д айлчлал хийж Америкийн худалдааны алдагдлыг багасгах үүднээс 16 тэрбум ам.долларын үнэ бүхий 106 багц гэрээнд гарын үсэг зурсан. Үүнд 4,6 тэрбум ам.долларын үнэ бүхий 80 онгоцыг Бойнг компаниас худалдан авах гэрээ орж байгаа юм.¹⁰

Америкийн Хятадтай хийж буй худалдааны алдагдлын талаар зарим судлаачид өөр байр суурь ч илэрхийлсэн байдаг. Тэдний үзэж байгаагаар “хаана худалдах ёстой тэр газраа үйлдвэрлэ” гэсэн өнөөгийн бизнесийн бичигдээгүй дүрмийг баримтлан Америкийн ихэнхи үйлдвэрлэгчид үйлдвэрээ зах зээлийн багтаамжтай, хямд ажиллах хүч зэрэг олон хүчин зүйлийг харгалзан Хятад зэрэг оронд үйлдвэрээ шилжүүлэн хилийн чанадад байршуулснаар хоёр дахь эдийн засгийн үүрэг гүйцэтгэдэг болсонтой холбоотой гэж үздэг.¹¹

Өнөөгийн байдлаар АНУ-ын Microsoft, General electric, IBM, Ford motors, General motors гэх мэт олон олон томоохон корпорациуд Хятадад үйлдвэрлэлээ нээж хөрөнгө оруулалт хийж үйлдвэрлэсэн газраа бүтээгдэхүүнээ борлуулах болсон нь АНУ-ын экспортын хэмжээ, өсөлт бага байх гадаад худалдааг алдагдалтай харагдах нэгэн үндсэн нөхцөл болж байна.

Нөгөө талаар Хятадын эдийн засаг өнөөдөр Америкийн эдийн засаг төдийгүй дэлхийн эдийн засагт хүчтэй нөлөөлөх чиг хандлагатай болж ирлээ. Хятадын эдийн засгийн өсөлт жилд дунджаар 9 орчим хувь байгаа нь энэ улсыг 2020 он гэхэд дэлхийд АНУ-ын дараа 2-р байрт ороход хангалттай үзүүлэлт хэмээн эдийн засагчид үзэж байна. “Энэ их өсөлт энэ зууны ноёрхлын хамгийн гол үйл явдал болж болох юм. Хөгжлийг ийм хурднаар хийж байсан улс өмнө нь байсангүй” хэмээн АНУ-аас БНХАУ-д элчин сайдаар сууж байсан Стэплетон Рой

онцлон тэмдэглэсэн байх юм.¹² Энэ өсөлтийг дагаад Хятад улсын үйлдвэрлэлийн бүтцэд ч өөрчлөлт шинэчлэлт бий болж байна. Урьд нь хүүхдийн тоглоом, бэлэн хувцас зэрэг ахуйн хэрэглээний зүйлс голлон үйлдвэрлэж байсан бол одоо хямд үнэтэй, чанартай оюуны өндөр багтаамжтай электрон цахилгаан хэрэгсэл, хагас дамжуулагч гэх мэт шинэ технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боллоо. Энэ нь Хятад улсын худалдааны нэр төрөл, бараа бүтээгдэхүүний нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Дээрхи үйл явцын өрнөлтөөс үзэхэд Америкийн Хятадтай хийж буй худалдааны алдагдлыг багасгах, Хятадын импортонд хязгаарлалт тавих нь тийм ч амар асуудал биш байх бололтой.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Олон улс судлал” сэтгүүл 2006 он, №2, 63х
2. www.census.gov/foreign-trade/top/index.html
3. http://www.brookings.edu/papers/2007/11_trade_woo.aspx
4. PRC General Administration of Customs, *China's Customs Statistics*.
5. Sources: US International Trade Commission, US Department of Commerce, and US Census Bureau
6. http://www.epi.org/content.cfm/briefingpapers_fdi_fdi
7. Sources: US International Trade Commission, US Department of Commerce, and US Census Bureau
8. Gray Clyde Hufbauer, Yee Wong and Ketki Sheth “US-China Trade Disputes: Rising Tide, Rising Stakes” 2006, p-78
9. www.imf.org/external/np/sta/ir/8802.pdf
10. “Growing Expectations for Hu Jintao’s Visit to the United States,” *Asia News*, April 10, 2006, available at www.asianews.it
11. Ц.Баатар “Глобалчлалын эриний Америкын эдийн засаг” 2004, ху-217
12. U.S.News&World Report June 20, 2005 p-40